



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өмнөговь аймгийн Даланзадгад сумын 8 дугаар цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: **ӨМА-2023/120/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас: www.audit.mn Өмнөговь аймаг 2023 он	Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр Утас: 70533539 Цахим хаяг: usukhbayarts@audit.gov.mn Аудитын менежер: Т.Хонгорзул Утас:99014247 Цахим хаяг: khongorzult@audit.gov.mn Ахлах аудитор: Ж.Болормаа Утас:80077408 Цахим хаяг: bolormaaja@audit.gov.mn Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Гэрэлт хөхийн тэнцвэр аудит ХХК Утас:99099119 Цахим хаяг:gerelthuhaudit@gmail.com
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2023.02.16 № 38

таний _____ -ны № _____ -т

ДАЛАНЗАДГАД СУМЫН 8-Р
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Б.НАСАНБАЯР ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Даланзадгад сумын 8 дугаар цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Даланзадгад сумын 8 дугаар цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн холбогдох заалтыг мөрдөөгүй, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, цалингийн урьдчилгааг ажилчдаас суутгаагүй, мөн авлагаар бүртгээгүй, бараа материалын тооллого хийгээгүй зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 18 дугаар зүйлийн 18.1 дахь заалттай тус тус нийцээгүй, "Тохиолдсон байх", "Иж бүрэн байх", "Нийцсэн бөгөөд зохистой байх", "Үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар цэцэрлэгийн барилгын их засварын ажлыг 640.0 сая төгрөгөөр хийсэн нь хүүхэд цэвэрхэн, тохилог орчинд сурах боломжийг бүрдүүлсэн байна.

01600050

Аудитын гол асуудал

Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтад "Хувьсах зардлын дундаж нормативаар санхүүжүүлэх аргачлал" батлагдаж боловсролын байгууллагын жилийн эцсийн дансны үлдэгдлийг дараагийн төсвийн жилд санхүүжүүлдэг болсон байна.

Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ӨСӨХБАЯР

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

(сая төгрөгөөр)		
Үзүүлэлт	2021.12.31	2022.12.31
Санхүүгийн байдлын тайлан		
Эргэлтийн хөрөнгийн дүн	76.5	145.3
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,293.4	1,926.3
Нийт хөрөнгийн дүн	1,369.9	2,071.6
Нийт өр төлбөрийн дүн	-	-
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,369.9	2,071.6
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,369.9	2,071.6
Санхүүгийн үр дүнгийн тайлан		
Үйл ажиллагааны орлогын дүн	434.1	1,334.4
Үйл ажиллагааны зардлын дүн	474.5	632.4
Үйл ажиллагааны үр дүн	(40.4)	702.0
Үйл ажиллагааны бус үр дүн	(1.7)	
Үйл ажиллагааны нийт үр дүн	(42.1)	702.0
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан		
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,112.7	2,070.6
Тайлант оны үр дүн	(42.1)	702.0
Эцсийн үлдэгдэл	2,070.6	2,772.6
Мөнгөн гүйлгээний тайлан		
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	434.1	659.6
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	434.1	581.3
Үйл ажиллагааны ЦМГ	-	78.3
Хөрөнгө оруулалтын ЦМГ	-	-
Санхүүгийн үйл ажиллагааны ЦМГ	-	-
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	-	-
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	630.7	547.3
Урсгал зардал	630.7	547.3
Хөрөнгийн зардал	-	-
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	630.7	625.6
Улсын төсвөөс санхүүжих	558.2	558.2
Орон нутгийн төсвөөс санхүүжих	72.5	67.4
Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас		
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		78.3

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 32.1 сая төгрөгийн 5 алдаа¹ илэрснээс 5 алдааг Даланзадгад сумын 2023 оны 02 сарын 09-ны өдрийн 22 дугаар албан бичгээр аудитын явцад залрууллаа. Үүнд:

Уурын зуухны дээврийн засвар нэртэй 12.0 сая төгрөгийн өртөгтэй хөрөнгийг уурын зуухны барилга дансанд, 1.1 сая төгрөгийн өртөгтэй хөрөнгийг өмнөх үеийн үр дүн дансанд хаасныг шилжүүлсэн хөрөнгө дансанд, барилгын их засварын зураг төсвийг мөнгөөр худалдан авсан хөрөнгөөр илэрхийлснийг шилжүүлсэн хөрөнгө дансанд, Цалингийн урьдчилгаа олгоод авлагаар бүртгээгүй 0.6 сая төгрөгийн авлага дансанд, 0.5 сая төгрөгийн ажилчдаас авах авлагыг цалингийн зардалд бичсэнийг өмнөх үеийн үр дүн дансанд залрууллаа.

Аудитаар нийт 7.7 сая төгрөгийн зөрчил² илрүүлж тус зөрчилд 0.7 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 2.4 сая төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлж 4.6 сая төгрөгийн 2 заалт бүхий зөвлөмж өгсөн.

3.1 Төлбөрийн акт

1. Цалингийн бүртгэлтэй холбоотой асуудал.

Илрүүлэлт: 2021 оны санхүүгийн тайлангаар өгсөн 1.4 сая, Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас өгсөн 0.6 сая нийт 2.0 сая төгрөгийн төлбөрийн актаас 1.3 сая төгрөгийг ажилчдаас суутган авч үлдэгдэл 0.7 сая төгрөгийг төсвөөс төлсөн зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “*төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2-т “*бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлагыг нягтлан бодох бүртгэлд заавал бүртгэнэ*” гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиудыг хэрэгжүүлэн ажиллаагүй тул 0.7 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоолоо.

3.2 Албан шаардлага

Илрүүлэлт: Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар 2.3 сая төгрөгийн авлагыг барагдуулан ажиллах албан шаардлага өгөгдсөн боловч 0.5 сая төгрөгийг барагдуулан үлдэгдэл 1.8 сая төгрөгийн авлага барагдаагүй, тайлант онд авлагыг 0.6 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “*төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*”, 6.4.8-д “*Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх*” гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хуулийг баримтлан насжилт өндөртэй болон тайлант онд шинээр цалинтай холбоотой авлагыг бүрэн барагдуулан ажиллах

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар хүнсний материал тоолоход дутагдсан 1.4 сая төгрөгийн бараа материалыг гарз дансанд хаахгүйгээр хүүхдийн хоолонд олгосноор бүртгэл хөтөлж бараа материалын эхний үлдэгдлийг бууруулжээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.3 “*эд хөрөнгө дутагдсан, эд хөрөнгийг хууль бусаар зарцуулсан байж болзошгүй гэж үзсэн үед хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг заавал хийнэ*” гэсэн заалттай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг баримтлан ажиллаж бараа материалын тооллогыг хөрөнгийн тооллоготой хамтад нь зохион байгуулж хэвших

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

2. Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Бат арвай трейд ХХК-иас 3.2 сая төгрөгийн компьютерыг цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 “Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно” гэсэн заалттай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасны дагуу цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад газраас худалдан авдаг байдлыг зогсоож хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 06 дугаар сарын 01 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

ДӨРӨВ. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/												
Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Уурын зуухны барилын дээвэр нэртэй хөрөнгөтэй	1	12,000.0			1	12,000.0	1	12,000.0				
хөрөнгийг тайлант оны үр дүн данстай харьцуулсан.	1	1,095.0			1	1,095.0	1	1,095.0				
Их засвартай холбоотойгоор зураг төсвийг тайлант оны үр дүн дансанд хаасан	1	18,000.0			1	18,000.0	1	18,000.0				
Авлагыг өөр цэцэрлэгээс хаасан ч цалингийн зардалд тусгасан	1	500.0			1	500.0	1	500.0				
Цалингийн урьдчилгаа олгоод авлагаар бүртгээгүй	1	550.0			1	550.5	1	550.5				
Дүн	5	32,145.0			5	32,145.0	5	32,145.0				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл												/мянган төгрөгөөр/		
Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										Хууль, хяналтын байгууллагд шилжүүлсэн асуудал	
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн		
Цалингаас суутгах суутгалуудыг дутуу суутгаж авлагаар бүртгээгүй	1	745.9	1	745.9										
Дутагдсан бараа материалыг хүүхдийн хоолонд зарцуулсан гэж зардалд бүртгэсэн	1	1,398.6					1	1,398.6						
Өмнөх аудитаар өгөгдсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй. Авлага нэмэгдүүлсэн	1	2,398.0			1	2398.0								
Дүн	3	4,542.8	1	745.9	1	2,398.0	1	1,398.6						

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

									/мянган төгрөгөөр/
Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
Алдаа илэрээгүй									
Дүн									
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил									
Төрийн хэмнэлтийн тухай	1	3,200.0					1	3,200.0	
Дүн	1	3,200.0					1	3,200.0	
Нийт дүн	1	3,200.0					1	3,200.0	

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо		Санал дүгнэлтийн хэлбэр
		Аудит хийсэн хэлбэр	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр	

			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй	Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1				1		
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1				1		